



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/305

Хэрлэн сум

RC-21 бүртгэл хяналтын системийг  
хөгжүүлэхэд зориулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, аймгийн Онцгой комиссын 2021 оны 6 дугаар сарын 30-ны 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хэмжээнд Коронавируст цар тахлын үед ашиглаж байсан RC-21 бүртгэл хяналтын системийн хөгжүүлэлтэд шаардагдах 1,350,000 (нэг сая гурван зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ